Төсөл

Засгийн газрын 2026 оны ... дугаар
сарын ... -ний өдрийн .. дугаар
тогтоолын хавсралт

ХЯЗГААРЛАГДМАЛ ОРЧИНД АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД МӨРДӨХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Зорилго, хамрах хүрээ

1.1.1.Ажилтан хязгаарлагдмал орчинд нэвтрэн ажиллах үед тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад тавигдах нийтлэг шаардлагыг тогтооход оршино.

1.1.2.Энэхүү техникийн зохицуулалтыг хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэдэг ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллага дагаж мөрдөх бөгөөд, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад ашиглана.

1.1.3.Далд уурхайн ажлын байр болон Онцгой байдлын ерөнхий газрын аврах ажиллагааны үеийн үйл ажиллагааг энэ зохицуулалтаар зохицуулахгүй. Энэхүү техникийн зохицуулалтыг хэрэгжүүлж буй байгууллагын дотоод аврах багийн ажиллагаанд хамаарна.

1.2.Норматив эшлэл

1.2.1.Энэхүү техникийн зохицуулалтад дараах иш татсан стандартууд болон холбогдох баримт бичгийг ашиглана. Он заагаагүй тохиолдолд тухайн стандартын хамгийн сүүлийн батлагдсан хувилбар түүний нэмэлт өөрчлөлтийн хамт мөрдөнө.

-MNS 4990. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисын хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага, зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

-MNS 6654. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл. Амьсгал хамгаалах хэрэгслийн сонголт, хэрэглээнд тавих ерөнхий шаардлага

1.3.Нэр томьёо,тодорхойлолт

Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.”хязгаарлагдмал орчин” гэж хүн байнга ажиллахад зориулагдаагүй, орц, гарц нь чөлөөтэй бус, агаар сэлгэлт хангалтгүй хагас эсвэл бүтэн хаалттай орчныг хэлнэ.

Тайлбар*: Хязгаарлагдмал орчин гэдэгт тухайн орчинд ажил гүйцэтгэж байгаа ажилтан амьсгалын дутагдалд орох, хийнд хордох, живэх, сорогдох, дарагдах, хавчигдах, осгох, тэсрэх, түлэгдэх шатамхай хий хуриммтлах, усны түвшин огцом нэмэгдэх, орон зайн даралт өөрчлөгдөх зэрэг аюултай нөхцөл үүсэх цонх агааржуулалтгүй тасалгаа, шингэн, хуурай материал хадгалах нөөц сав, дулаан, хий, ус, бохир дамжуулах шугам хоолойн худаг (траншей), шугам, утаа, агаар дамжуулах яндан хоолой, халаалтын зуух, нүүрснээс хий ялгах зуух, баяжуулах үйлдвэрийн болон уурхайн томоохон төхөөрөмжийн хоолой хийц,*

төмөрлөгийн үйлдвэрийн шанага, зуух хийц, бусад төрлийн хагас эсвэл бүтэн хаалттай орчин хамаарна.

1.3.2.”эрсдэлийн үнэлгээ” гэж хязгаарлагдмал орчинд ажилтан нэвтрэхээс өмнө тухайн орчноос ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аюулыг илрүүлэх, тохиолдож болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнийг арилгах, бууруулах арга хэмжээг тодорхойлох үйл ажиллагаа;

1.3.3.”хязгаарлагдмал орчинд нэвтрэх” гэж тухайн ажлыг хариуцаж байгаа ажилтнаас олгосон зөвшөөрлийн дагуу ажилтан толгой эсвэл бүтэн биеэрээ хязгаарлагдмал орчинд нэвтрэхийг;

1.3.4.”Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл” гэж хязгаарлагдмал орчноос ажилтны амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээнд үндэслэн олгодог бичгээр үйлдсэн зөвшөөрөл.

1.3.5.“ахлах ажилтан” гэж хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх ажлыг зохион байгуулах, эрсдэлийн үнэлгээ хийлгэх, ажилтанд зааварчилгаа өгөх, нэвтрэх зөвшөөрөл хүсэх, ажлын явцад хяналт тавих үүрэг бүхий тухайн нэгжийн хариуцлагатай албан тушаалтныг хэлнэ.

1.3.6.”хяналтын ажилтан” гэж хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн ажилтны аюулгүй байдалд байнгын хяналт тавих, тэдэнтэй харилцаа холбоотой байх, ослын үед орчинд нэвтрэн ажиллахгүй бөгөөд анхны мэдэгдэл хийх, аврах багийг дуудах, ослын бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу харилцаа холбоо хангах үүрэгтэй ажилтныг хэлнэ.

1.3.7.“хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаагаар мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд (ХАБЭМ)-ийн ажилтан” гэж энэ техникийн зохицуулалтын 8.3-т заасан хугацаа, агуулгатай сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн, хязгаарлагдмал орчны эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт тавих чадамж бүхий ХАБЭМ-ийн ажилтныг хэлнэ.

1.3.8.“ослын бэлэн байдлын төлөвлөгөө” гэж хязгаарлагдмал орчинд осол, аюул тохиолдсон үед ажилтныг аюулгүй нүүлгэн шилжүүлэх, аврах, анхны тусламж үзүүлэх, холбогдох байгууллагад мэдэгдэх үйл ажиллагааны дараалал, хариуцсан этгээд, ашиглах нөөц, хэрэгслийг тодорхойлсон баримт бичгийг хэлнэ.

1.3.9.“аврах баг” гэж хязгаарлагдмал орчинд осол гарсан үед аврах ажиллагаа гүйцэтгэхээр байгууллагаас томилогдож, тусгай сургалт, бэлтгэл хангагдсан ажилтнуудын бүлгийг хэлнэ. Харин мэргэжлийн аврах ажиллагааг онцгой байдлын алба хаагчид гүйцэтгэнэ.

Хоёр.Ажилтныг хязгаарлагдмал орчинд аюулгүй ажиллахад тавих ерөнхий шаардлага

2.1.Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэдэг ажил олгогч энэхүү техникийн зохицуулалтад нийцүүлэн “Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны журам”-ыг боловсруулж батлан, үйл ажиллагаандаа мөрдөнө.

2.2.Ажил олгогч нь энэхүү техникийн зохицуулалтын 2.1-д заасан журмын хэрэгжилтийг хариуцах ба хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаанд мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд хариуцуулан, хэрэгжилтэд тогтмол хяналт тавина.

2.2.1.Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаанд мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь аж ахуй нэгж, байгууллагын хэмжээнд хэрхэн

ажиллах эрх, үүргийн матрицыг тодорхойлж, баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэн, хяналт тавьж ажиллана.

2.2.2.ХАБЭМ-ийн ажилтангүй аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэшсэн мэргэжилтэн эсвэл мэргэжлийн байгууллагаар хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

2.3.Ажил олгогч өөрийн эзэмшлийн эсвэл түр ашигладаг барилга байгууламж, дэд бүтцэд хамаарах байнгын хязгаарлагдмал орчныг нэг бүрчлэн бүртгэж, аюулын талаарх анхааруулга, болон зөвшөөрөлгүй нэвтрэхийг хориглосон тэмдэг, тэмдэглэгээ байршуулж, холбогдох хаалт, хашлагаар хамгаалсан байна.”

2.4.Ажил олгогч нь өөрөө болон хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхэд оролцдог бүх ажилтныг сургалтад хамруулж хязгаарлагдмал орчинд аюулгүй ажиллахад шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлсэн байна.

2.5.Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхээс өмнө тухайн орчинд нэвтрэхгүйгээр эрсдэлгүй аргаар ажил гүйцэтгэх боломжийг тодорхойлно. Ийм боломжгүй тохиолдолд хязгаарлагдмал орчинд энэ техникийн зохицуулалтын дагуу аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.

2.6.Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх нэгжийн ахлах ажилтан эрсдэлийн үнэлгээ хийж, нэвтрэх зөвшөөрлийг ажил олгогчоос авч, ажил гүйцэтгэх ажилтнуудад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, хяналт тавин ажиллана.

2.7.Хязгаарлагдмал орчны нээлттэй хэсгийн эргэн тойронд хаалт, хашлага, хамгаалалтыг хийж ажилтан, эд зүйл унахаас сэргийлж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байрлуулж, шаардлагатай бусад эрсдэлийн хяналтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.8.Хүн орж ажил гүйцэтгэх хязгаарлагдмал орчин хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.8.1.орчны гэрэлтүүлгийн хэмжээ 100 лк-ээс багагүй, зөөврийн гэрэл ашигладаг газардуулгатай,

2.8.2.эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон эрсдэлийг ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд аюулгүй (хүлцэх) түвшинд хүртэл бууруулсан;

2.8.3.агаарын чанарын үзүүлэлт MNS 4990 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд;

2.8.4.ажлын явцад механик агааржуулалт, бусад техник технологийн арга хэмжээ хэрэглэдэг бол эдгээр нь ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

2.9.Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх ажилтанд газ детектор багаж зүүлгэж, хүчилтөрөгч, шатамхай болон хорт хийн түвшинд тогтмол хяналт тавина.

2.10.Ажлын явцад хяналтын ажилтан ажил гүйцэтгэж буй ажилтантай харилцаа холбооны боломжит хэрэгслээр тогтмол холбоотой байж, аюулгүй байдалд нь хяналт тавьж ажиллана. Хяналтын ажилтан хяналт тавьж ажиллах үедээ давхар ажил үүрэг гүйцэтгэхгүй.

2.11.Ажил гүйцэтгэж байгаа хязгаарлагдмал орчны агаарын найрлага өөрчлөгдөж аюул үүсэх, ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн тохиолдолд тухайн ажлыг зогсоож, ослын бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

2.12.Барилга байгууламж эзэмшигч эсвэл түр ашиглагч аливаа хязгаарлагдмал орчны орц, гарцыг ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй байхаар төлөвлөж, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.13.Аж ахуйн нэгж, байгууллага хязгаарлагдмал орчны тоог хамгийн боломжтой хэмжээнд цөөрүүлэхэд чиглэсэн техник технологи, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Гурав.Хязгаарлагдмал орчны бүртгэл

3.1.Хязгаарлагдмал орчныг тодорхойлж, бүртгэх асуудлыг ажил олгогч хариуцаж, дараах дарааллын дагуу хийнэ;

3.1.1.ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллага эзэмшдэг эсвэл түр ашигладаг барилга байгууламж, дэд бүтцэд хамаарах хагас болон бүтэн хаалттай бүх орчны жагсаалтыг гаргах;

3.1.2.жагсаалт дахь хаалттай орчноос ажилтан толгой эсвэл бүтэн биеэ оруулж ажиллах шаардлагатай орчныг сонгох;

3.1.3.жагсаалтаас байнгын ажлын байрны зориулалттай төлөвлөгдсөн, хангалттай агааржуулалттай, орц, гарц нь чөлөөтэй хаалттай орчныг үнэлгээнээс хасна. Харин хүн байнга ажиллахад зориулагдаагүй, орц, гарц нь чөлөөтэй бус, агааржуулалт хангалтгүй орчныг сонгож үнэлгээний үйл явцыг үргэлжлүүлэн

3.1.4. Дээрх шалгууруар сонгосон хаалттай орчноос хортой, шатах, тэсрэх аюултай хий ялгарах, агаар дахь хүчилтөрөгчийн дутагдал (19.5%-аас бага) эсвэл хэт илүүдэл (23.5%-аас их) үүсгэж болзошгүй орчныг хязгаарлагдмал орчинд тооцно.

Тайлбар: *Маш олон төрлийн нөхцөл байдлын улмаас хязгаарлагдмал орчны агаарт хорт хий, шатамхай хий ялгарч, хүчилтөрөгчийн хэмжээ аюултай түвшинд хүрдэг. Тухайлбал бохир ус зайлуулах суваг,ус түгээх шугам хоолой, холбооны кабелийн суваг, худаг зэрэг орчны агаарт хүхэрт устөрөгч, аммиак, нүүрстөрөгчийн дутуу исэл, метаны хий хуриматлагдаж хүчилтөрөгчийн агууламж буурах эрсдэлтэй. Шатахуун болон химийн бодис хадгалах, тээвэрлэх явцад савны үлдэгдэл нь дэгдэж тархсанаас хурц хордлого үүсгэх эрсдэлтэй. Худаг, нөөцлүүр сав, агаар сэлгэлтгүй битүү өрөө, давчуу хийц, байгууламжид гагнуур, будгийн ажил хийх, уусгагчаар цэвэрлэх үед хорт бодис их хэмжээгээр ялгардаг.*

3.1.5.дээрх нөхцөл тодорхойлогдоогүй ч ажилтан ажлаа хийх явцад дарагдах, живэх, гацах, урсах, татагдах, сорогдох гэх мэт аюул үүсэж болзошгүй орчныг хязгаарлагдмал орчинд тооцно.

3.2.Аж ахуйн нэгж, байгууллага энэ техникийн зохицуулалтын 3.1-д заасан шалгуурт нийцсэн хязгаарлагдмал орчныг нэг бүрчлэн бүртгэж, дараах агуулгаар бүртгэл хөтөлнө. хөтөлнө:

3.2.1.хязгаарлагдмал орчны байршил, шинж байдлын тодорхойлолт, ялгах дугаар;

3.2.2.хязгаарлагдмал орчинд нэвтэрч ажил гүйцэтгэх шаардлагатай нэгж эсвэл ажилтнууд;

3.2.3.хязгаарлагдмал орчныг хариуцагч (Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаанд мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, хязгаарлагдмал орчны орчны аюулгүй ажиллагаанд мэргэшсэн ажилтан);

3.2.4.хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл хүсэх, хянах, батлах албан тушаалтан.

3.3.Бүртгэлжүүлсэн бүх хязгаарлагдмал орчны гадна аюулыг анхааруулсан болон

нэвтрэхийн тулд зөвшөөрөл авсан байх шаардлагатай гэсэн тэмдэглэгээг байрлуулна. Тухайн орчны ойр ажилладаг ажилтнуудад хязгаарлагдмал орчны аюулын талаар мэдээлэл өгч, ойлголт, мэдлэгийг эзэмшүүлнэ.

3.4.Хязгаарлагдмал орчны бүртгэлийг жил тутам хянаж, шинэчилнэ.

3.5. Шинээр барилга, дэд бүтэц байгуулах, засвар, өргөтгөл хийх, үйлдвэрийн тоног төхөөрөмж шинээр суурилуулах бүрд хязгаарлагдмал орчныг тодорхойлох үнэлгээ хийж, бүртгэл хөтөлнө. Аль болох хязгаарлагдмал орчин бүхий ажлын байрны тоог нэмэхгүй байхад анхаарах.

Дөрөв.Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл

4.1.Хязгаарлагдмал орчинд нэвтрэх ажил гүйцэтгэх нэгжийн ахлах ажилтан Хавсралт 1-д заасан маягтаар гаргасан хүсэлтийн дагуу ажил олгогч нэвтрэх зөвшөөрөл олгоно.

4.2.Ахлах ажилтан зөвшөөрөл хүсэхээс өмнө ажил гүйцэтгэх хязгаарлагдмал орчны эрсдэлийн үнэлгээг Хавсралт 2-ын дагуу хийж, ХАБЭМ-ийн ажилтан эсвэл хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаанд мэргэшсэн ажилтнаар хянуулна. ХАБЭМ-ийн ажилтан эсвэл хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаагаар мэргэшсэн ажилтангүй байгууллага нь мэргэшсэн мэргэжилтэн эсхүл мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

4.3.ХАБЭА-н ажилтан хязгаарлагдмал орчны эрсдэлийн үнэлгээний үр дүнг хянаж, дараах шалгуурыг хангасан бол нэвтрэх зөвшөөрөл олгох саналыг ажил олгогчид гаргана:

4.3.1.хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх ажилтны амь нас, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй аюулыг бүрэн илрүүлж, эрсдэлийг нь үнэлсэн;

4.3.2. хязгаарлагдмал орчны агаар дахь хүчилтөрөгчийн хэмжээ 19.5-23.5% хооронд, шатамхай хий, уурын түвшин 10% эсвэл тэдгээрийн тэсрэх доод хязгаараас бага, хорт бодисын хэмжээ MNS 4990 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй;

4.3.3.ажил гүйцэтгэх орчны агааржуулалт хангалттай, хортой, аюултай бодис дэгдэх эрсдэлтэй бол зайлуулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөсөн;

4.3.4.үнэлгээгээр тодорхойлсон эрсдэлийн түвшин хүлцэх түвшинд эсвэл хүлцэх түвшинд хүртэл арилгах, бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангалттай төлөвлөсөн;

4.3.5.хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэж байгаа ажилтны аюулгүй байдалд хяналт тавих, шаардлагатай үед хэрэгжүүлэх ослын бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой.

4.5.Эрсдэлийн үнэлгээгээр хязгаарлагдмал орчин дахь эрсдэлийг бүрэн тодорхойлоогүй эсхүл эрсдэлийг хүлцэх түвшинд хүртэл арилгах, бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангалттай төлөвлөөгүй бол зөвшөөрөл олгохгүй.

4.6.Шаардлагатай гэж үзвэл ХАБЭМ-ийн ажилтан эрсдэлийн үнэлгээг хийж, үр дүнг нь баталгаажуулна.

4.7.Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн маягтыг 3 хувь хөтөлж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан эсвэл хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаанд мэргэшсэн ажилтнаар хянуулсны дараагаар ажил олгогчоор батлуулснаар хүчин төгөлдөр болно. Зөвшөөрлийн маягтыг тухайн байгууллага үйл ажиллагааны онцлогтоо тааруулан цахим болгон ашиглах боломжтой тохиолдолд зохион байгуулалтын мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг арилгах, бууруулах төлөвлөгөө, ослын бэлэн

байдлын төлөвлөгөөг системд оруулах, танилцах, баталгаажуулах, мэдээллийн үнэн зөв, хүртээмжтэй байдлыг хангана.

4.8.Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн 1 хувийг хүсэлт гаргасан ахлах ажилтан, 1 хувийг хянаж, баталсан ажил олгогч хадгалж, 1 хувийг ажил гүйцэтгэх талбайн бүдүүвч зургийн хамт хязгаарлагдмал орчны орох хэсэгт харагдахуйцаар байрлуулна.

4.9.Ажилтан хязгаарлагдмал орчинд ажлаа дуусгаж гарч ирсний дараа зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зурна. Ажил дууссан талаарх мэдэгдлийг ахлах ажилтнаас ажил олгогчид өгч, хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийг хүчингүй /дуусгавар гэх/ болгуулна.

4.10.Зөвшөөрлийг хаахдаа өмнө дараахыг нягтална.

4.10.1.хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн ажилтнууд бүгд гарсныг нотолж зөвшөөрлийн маягт дээр гарын үсэг зуруулсан байх;

4.10.2.хязгаарлагдмал орчинд ажлын багаж, хэрэгсэл үлдээгүй болохыг шалгасан бүртгэл.

4.11.Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх үед ХАБЭМ-ийн журам зөрчигдсөн, эрсдэлтэй нөхцөл үүссэн / техникийн саатал, цаг агаарын нөлөө, технологийн горим, тоног төхөөрөмжийн өөрчлөлт, материалын төрөл солигдох зэрэг аюул нэмэгдүүлэх хүчин зүйл илэрсэн тохиолдолд/ тохиолдолд нэвтэрсэн ажилтныг нэн даруй гаргаж, зөвшөөрлийг хүчингүй болгуулна. Зөвшөөрөл хүчингүй болгуулах асуудлыг ахлах хариуцан ХАБЭМ-ийн ажилтанд танилцуулж, ажил олгогчоор хүчингүй болгоно.

4.12.Аврах ажиллагааны зорилгоор хязгаарлагдмал орчинд агаарын чанарын хэмжилт хийхгүйгээр нэвтрэхийг зөвшөөрнө.

4.13.Агаарын чанарын хэмжилт, эрсдэлийн үнэлгээ хийх ажилтан хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн хүсэлтийг ажил олгогчид гаргах ба зөвшөөрлийн маягтын агаарын чанарын хэмжилтийн хэсгийг бөглөхгүй.

4.14.Нэвтрэх ажилтан агаар нөөцлөгчтэй, бүрэн ажиллагаатай амьсгалын аппарат, бусад шаардлагатай хамгаалах хувцас, хэрэгслээр хангагдсан байх ба бүрэн зөв ашиглах чадварыг эзэмшсэн байна.

Тав. Агаарын чанарын хэмжилт

5.1.Агаарын чанарын хэмжилтийг хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл авахын өмнө болон хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх явцад тогтмол хийнэ.

5.2.Агаарын чанарын хэмжилт хийх ажилтан сургалтад хамрагдаж хэмжилт хийх арга зүй, хэмжилтийн багажийг ашиглах, үр дүнг нь дүгнэх чадамжийг эзэмшсэн байна.

5.3.Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл хүсэхээс өмнөх агаарын чанарын хэмжилт хийхэд дараах шаардлагыг мөрдөнө:

5.3.1.хэмжилтээр хүчилтөрөгч (O2), шатамхай хийн хувь, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), хүхэрт устөрөгч(H2S), метан(CH4), аммиак (NH4)-ын концентрацийг тодорхойлох ба тухайн орчинд ач холбогдолтой агаарын чанарын бусад үзүүлэлтийг нэмэлтээр хэмжих;

5.3.2.нэмэлт насос, хоолой(проб)-оор тоноглогдсон газ детектор багаж ашиглан ажилтан хязгаарлагдмал орчин руу нэвтрэхгүйгээр хэмжилт хийх;

5.3.3.хэмжилтийн үр дүнг зөвшөөрлийн маягтад тэмдэглэх ба хэмжилтийн үр дүн тухайн өдрөө хүчинтэй байна;

5.3.4.хэмжилтийн үр дүн MNS 4990 стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд зохиомол агааржуулалтаар хязгаарлагдмал орчны агаарын чанарыг сайжруулсны дараа хэмжилтийг давтаж хийнэ.

5.4.Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх үед хийх агаарын чанарын хэмжилтийн үед дараах шаардлагыг мөрдөнө:

5.4.1.ажилтны амьсгалын түвшинд газ детектор багажийг зүүлгэж, ажлын явцад агаарын чанарын үзүүлэлтэд тасралгүй хяналт тавина;

5.4.2.хэмжилтэд ашиглах газ детектор багаж ажилтан зүүж хэрэглэхэд тохиромжтой овор хэмжээ багатай, агаарын чанарын үзүүлэлт аюултай түвшинд хүрэхэд дуут дохио өгөх боломжтой байна;

5.4.3. энэ техникийн зохицуулалтын 5.3.1-д заасан үзүүлэлтийг хэмжих;

5.4.4.нэг орчинд хоёроос олон ажилтан ажиллаж байгаа тохиолдолд тэдний төлөөлөл болгож 1-3 хүнд хий илрүүлэгч багаж зүүлгэж болно.

5.4.5.газ детектор аюулын дохиолол өгсөн үед хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн бүх ажилтныг нэн даруй гаргаж, эрсдэлийн үнэлгээ хийж, нэвтрэх зөвшөөрлийг ажил олгогчоос дахин хүсэх;

5.1.6.агаарын чанарын явцын хэмжилтийн үр дүнг хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн маягтад тэмдэглэнэ.

5.5.Хязгаарлагдмал орчны агаарын даралт гадаад орчны даралтаас их байх нөхцөлд тагийг нээх үед хуримтлагдсан хортой, аюултай бодис дэгдэж хэмжилт хийх ажилтанд өртөх эрсдэл үүсэх тул тагийг нээснээс хойш дор хаяж 15 минут хүлээн даралтыг тэнцвэржүүлнэ. Үүний дараа агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэнэ.

5.6.ХАБЭА-н ажилтан агаарын чанарын хэмжилтэд ашигладаг газ детектор багажийн хэвийн ажиллагааг үйлдвэрлэгчийн зааврын дагуу өдөр тутам шалгаж, зөв хэрэглээнд нь хяналт тавина.

Тайлбар: *Ихэнх төрлийн газ детектор багажийн мэдрэгч 2-3 жилийн хугацаанд ашиглах зориулалттай. Тиймээс хий илрүүлэгч багажийн мэдрэгчийг дээрх хугацаанд сольж, хэвийн ажиллагааг нь хангана.*

5.7.Агаарын чанарын хэмжилтэд ашигладаг газ детектор багажийг тухайн багажийн загвар, ашиглаж буй мэдрэгчийн төрөл, үйлдвэрлэгчийн заавар, ашиглалтын нөхцөлөөс хамааруулан хугацаат баталгаажилтын хугацаа гаргаж, 3-12 сар тутамд итгэмжлэгдсэн лаборатори эсвэл үйлдвэрлэгчээс нь зөвшөөрөгдсөн байгууллагад шалгалт тохируулга хийлгэж, баталгаат байдлыг хангана.

Зургаа. Эрсдэлийн удирдлагын ерөнхий зарчим

6.1.Ажил олгогч хязгаарлагдмал орчинд нэвтрэхгүйгээр эрсдэлгүй аргаар ажил гүйцэтгэх боломжийг тодорхойлно. Ийм боломжгүй, зайлшгүй хязгаарлагдмал орчинд нэвтрэн ажил гүйцэтгэх шаардлагатай бол дараах зарчмаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

6.2.Хязгаарлагдмал орчинд нэвтрэхээс өмнө эрсдэлийн үнэлгээг орчны онцлог, нөхцөлөөс хамааран хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар хийж, ажил гүйцэтгэх үед үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлно. Эрсдэлийн үнэлгээгээр дараах төрлийн аюулыг

илрүүлэх ба үүгээр хязгаарлагдахгүй:

- орц, гарцыг хязгаарласан саад;
- агаарын чанарын үзүүлэлт, хортой, аюултай хий, уур, тоосонцор;
- гэрэлтүүлгийн нөхцөл байдал,
- физикийн аюултай хүчин зүйлс (шуугиан, доргион, ионжуулагч цацраг, цахилгаан соронзон цацраг, халуун температур, хүйтэн осгох, хөлдөх, түлэгдэх, цахилгааны аюул гэх мэт,)
- галын аюул (шатамхай хий, хүчилтөрөгчийн илүүдэл, галын эх үүсвэр);
- шингэн, хуурай материалд живэх, дарагдах аюул;
- биологийн аюул (вирус, бактери, мөөгөнцөр, харшил-хэт мэдрэгшил үүсгэгч);
- Механик аюул болон эргономикийн сөрөг хүчин зүйлс (ажилтны биеийг зүсэх, цохих зэргээр гэмтээх, хүнд зүйл өргөх, албадмал байрлалд ажиллах гэх мэт);
- Тухайн орчны нөхцөлөөс хамаарах бусад аюул.

6.3.Эрсдэлийн үнэлгээгээр ажил гүйцэтгэх хязгаарлагдмал орчин ажилтны амь нас, эрүүл мэндэд хүлцэшгүй эрсдэлтэй нь тогтоогдвол эрсдэлийг арилгах эсхүл хүлцэх түвшинд хүртэл бууруулах шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлсний дараа нэвтрэх зөвшөөрөл олгоно.

6.4.Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг мөрдөнө:

6.4.1.хязгаарлагдмал орчинд нэвтрэхгүйгээр ажил хийх арга, техник технологийн ашиглах зэргээр аюулыг арилгах арга шийдлийг нэн тэргүүнд сонгох;

6.4.2.хязгаарлагдмал орчинд нэвтрэн ажил гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай бол аюулын эх үүсвэрийг орлуулах, тусгаарлах, техник технологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг дангаар эсхүл хослуулан хэрэглэнэ.

6.4.3.хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх нөхцөлд эрсдэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

i.хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн ажилтны аюулгүй байдалд хяналт тавих хяналт зорилгоор хяналтын ажилтан ажиллуулж, шаардлагатай үед ослын бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

ii.хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн ажилтанд газ детектор багаж зүүлгэж агаар дахь хүчилтөрөгч, шатамхай, хорт хийн хэмжээг тогтмол хянаж, аюултай түвшинд хүрсэн тохиолдолд ажилтныг нэн даруй хязгаарлагдмал орчноос гаргах;

iii.орчны бичил цаг уур(температур, чийглэг, агаарын урсгалын хурд)-ын хэмжилт хийж, ажилтнууд дулааны стресст өртөх, осгох, хөлдөхөөс сэргийлэх;

iv.орчны гэрэлтүүлгийн хэмжилт хийж, 100 лк-ээс багагүй байх нөхцөлийг бүрдүүлж, үзэгдэх орчныг сайжруулах;

v.шаардлагатай бусад аюулд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх.

6.4.4.хэмжилтээр хязгаарлагдмал орчны агаарын чанар MNS 4990 стандартын шаардлага хангахгүй байгаа нь тодорхойлогдвол механик агааржуулалт хийнэ. Хязгаарлагдмал орчны агааржуулалтад дараах ерөнхий шаардлагыг мөрдөнө:

i.агааржуулалт нь ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө

үзүүлэхгүй байхаар төлөвлөх;

ii.цэвэр агаар оруулах, бохир агаарыг зайлуулахад зөөврийн эсвэл суурин механик агааржуулалтыг ашиглах;

iii.зайлуулж буй бохир агаар буцаж орохоос сэргийлж, агаар зайлуулах, оруулах хоолойнуудыг хангалттай хол зайнд байрлуулна.

iv.механик агааржуулалтаар оруулах агаарт тоос, хорт бодис зэрэг аливаа хольц, бохирдолгүй байх, MNS 4990 стандартын шаардлагыг хангасан байх;

v.хязгаарлагдмал орчин дахь ажилтны байрлаж буй талбай руу агаарын урсгал чиглэх

vi.зайлуулж байгаа бохир агаар ойр орчмын оршин суугчид, бусад хүмүүст сөргөөр нөлөөлөхгүй байх;

vii.агааржуулалтын төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, үр нөлөөг тогтмол шалгаж, хяналт тавих

6.4.5.аюултай байж болзошгүй тоног төхөөрөмж, хүчний эх үүсвэр, хий, уур, шингэний урсгал, энерги, ус зэргийг хааж, хязгаарлагдмал орчинд хүн нэвтрэхээс өмнө тусгаарлах цоожлох, пайзална.

6.4.6.эрсдэлийн үнэлгээнд үндэслэн шаардлагатай бол ажил гүйцэтгэх хязгаарлагдмал орчинд цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийнэ. Цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх ажилтан зөвшөөрөл авч, тусгай хувийн хамгаалах хэрэгслээр хангагдаж, ХАБЭА-н дүрэм журам, зааврыг чанд мөрдөж ажиллана.

6.4.7.даралтат болон шингэрүүлсэн хийн савыг хязгаарлагдмал орчинд ашиглах бол дараах шаардлагыг хангана:

i.агаар нөөцлөгчтэй амьсгалын аппаратаас бусад төрлийн даралтад хийтэй савыг хязгаарлагдмал орчинд авч орохыг хориглох;

ii.гидралик багажийн шингэн дамжуулах хоолойг шалгаж бүрэн бүтэн байдлыг хангах;

iii.гидралик багажийн дамжуулах хоолойг гэмтэхээс хамгаалж, байрлуулах, зориулалтын газар хадгалах;

iv.ашиглаагүй үед ажлын бүх багаж төхөөрөмжийг унтраах.

6.4.8.зөөврийн цахилгаан багажуудыг хязгаарлагдмал орчинд ашиглахдаа давхар тусгаарлагдсан, зөөврийн газардуулгын бүрэн хамгаалалттай байх, цахилгааны кабелиудыг тээглэх, хавчуулагдах, татагдах аюулгүйгээр байрлуулсан байх шаардлагатай.

6.5.Хязгаарлагдмал орчинд нэвтэрсэн болон хяналт тавих ажилтнуудыг тохиромжтой харилцаа холбооны хэрэгслээр хангаж, тогтмол харилцаатай байх боломжийг бүрдүүлнэ. Шаардлагатай үед ослын бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

6.6.Газрын түвшнээс доош орсон худаг зэрэг хязгаарлагдмал орчинд ажилтан нэвтрэх бол орц хэсэгт аюулгүй буух бэхэлгээ байрлуулж, өндрийн бүсээр ажилтныг хангана.

6.7.Механик агааржуулалтаар хязгаарлагдмал орчны агаарын чанарыг сайжруулах боломжгүй ч тухайн орчинд зайлшгүй нэвтрэх шаардлагатай тохиолдолд ажилтныг агаар хангамжтай амьсгал хамгаалах хэрэгсэл эсхүл агаар нөөцлөгчтэй амьсгалын аппаратаар хангана. Амьсгал хамгаалах хэрэгслийн сонголт, хэрэглээнд MNS 6654 стандартыг мөрдөнө.

6.8.Ажил гүйцэтгэх ажилтан нь аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн журмыг чанд мөрдөж ажиллана. Журмын хэрэгжилтэд хяналт тавих үүргийг нэгж хэлтсийн ахлах

ажилтан, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан хүлээнэ. Аюулгүй ажиллагааны журам зөрчигдөж буйг мэдсэн хэн боловч нэн даруй мэдээлнэ.

Долоо.Аврах ажиллагааны ерөнхий зарчим

7.1.Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэдэг байгууллага ослын үед хэрэгжүүлдэг Ослын бэлэн байдлын төлөвлөгөөтэй байх ба үүний бэлэн байдлыг тогтмол хангана.

7.2.Газар зүйн байршил, үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн төрлөөс хамаарч аж ахуйн нэгж байгууллага аврах баг, ажилтантай байж болно.

7.3.Аврах ажилтан нь онцгой байдлын мэргэжлийн байгууллагын сургалтад хамрагдаж, осолдогчид анхны тусламж үзүүлэх, хязгаарлагдмал орчинд аврах ажиллагаа явуулах, хувийн хамгаалах хэрэгсэл, аврах ажиллагааны багаж хэрэгслийг хэрэглэх чадамжийг эзэмшсэн байна. Сургалт зохион байгуулсан байгууллага нь аврах ажилтны чадамжийг үнэлж, баталгаажуулна.

7.4.Аврах ажиллагааг хоёр ба түүнээс олон тооны чадамжтай ажилтан гүйцэтгэнэ. Шаардлагатай нөхцөл байдалд мэргэжлийн байгууллагын тусламжийг авна.

7.5.Аврах баг нь аврах ажиллагаанд ашиглах хангалттай тооны шаардлага хангасан амьсгалын аппарат, аюулгүйн бүс, бэхэлгээ, аврах хэрэгсэл, амилуулах багажтай байна. Эдгээр багаж, хэрэгсэл нь ашиглахад бэлэн, зохих ёсоор техник үйлчилгээ, баталгаажуулалтад хамрагдсан байна.

7.6.Аврах ажилтан 7.5-д заасан багаж хэрэгслийн бэлэн, найдвартай байдлыг сар тутам шалгаж, тэмдэглэл хөтөлж, тайлан гаргана.

7.7.Ослын бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу сургуулилтыг сар тутам хийнэ.

7.8.Аврах баг хязгаарлагдмал орчинд нэвтрэхээс өмнө орчны нөхцөл байдалтай сайтар танилцсан байна.

7.9.Ослын үед аврах ажиллагаа явуулах зорилгоор хязгаарлагдмал орчин руу нэвтрэхэд зөвшөөрөл, эрсдэлийн үнэлгээ шаардагдахгүй. Гэхдээ тухайн тохиолдол, нөхцөл байдалтай уялдуулан ажиллах тактикаа маш сайн боловсруулж өөрсдөө аюул, осолд өртөхөөс сэргийлж, өндөр сонор сэрэмжтэй ажиллана.

Найм.Сургалт

8.1.Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхтэй холбоотой харилцаанд оролцдог ажил олгогч, удирдах албан тушаалтан, ХАБЭА-н ажилтан, ахлах ажилтан, ажил гүйцэтгэх болон хяналтын ажилтан хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж, зохих чадамжийг эзэмшсэн байна.

8.2.Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл олгодог ажил олгогч, удирдах албан тушаалтан мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан 6-аас доошгүй цагийн дараах агуулгатай сургалтад хамрагдаж, шалгалтад нь тэнцсэн байна.

- Хязгаарлагдмал орчны тухай ойлголт
- Хууль тогтоомж, техникийн зохицуулалтын шаардлага
- Хязгаарлагдмал орчны эрсдэлийн үнэлгээ
- Агаарын чанарын хэмжилт
- Хязгаарлагдмал орчны эрсдэлийн удирдлага
- Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл
- Ослын бэлэн байдал, аврах ажиллагаа

8.3.Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтийг хариуцах

ажилтан 24-өөс доошгүй цагийн онол, дадлага хосолсон мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байна. Сургалтын хөтөлбөр нь 8.2-д заасан агуулгатай байна.

8.4.Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаагаар мэргэшсэн ХАБЭА-н ажилтан нь хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэх болон, хяналт тавих үүрэг бүхий ажилтнуудад зориулсан сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна. Байгууллага нь дотоод нөөц бололцоогоор уг сургалтыг хийх боломжгүй тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандан сургалтыг гүйцэтгүүлнэ.

8.5. Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхтэй холбоотой харилцаанд оролцдог ажил олгогч, удирдах албан тушаалтан, ХАБЭА-н ажилтан, ахлах ажилтан, ажил гүйцэтгэх болон хяналтын ажилтанд зориулсан сургалтад хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмыг мөрдөнө.

төгсөв.

ТӨСӨЛ

Хавсралт 1.

ХЯЗГААРЛАГДМАЛ ОРЧИНД НЭВТРЭХ ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ

Байгууллагын нэр:		Зөвшөөрөл олгосон огноо:	__он__сар__өдөр
ХО-ны байршил:			
ХО-ны тодорхойлолт:		Зөвшөөрөл дуусах огноо:	__он__сар__өдөр
Нэвтрэх зорилго:			

АГААРЫН ЧАНАРЫН ХЭМЖИЛТ

Үзүүлэлт	Нэвтрэхээс өмнөх дүн	Явцын хэмжилтийн дүн				
Хүчилтөрөгч (19.5-23.5:%)						
Шатамхай хий LEL (<10%)						
Угаарын хий (<25 ppm)						
Хүхэрт устөрөгч (<10 ppm)						
Хорт хий 1:						
Хорт хий 2:						
Нэвтрэхээс өмнөх хэмжилт хийсэн ажилтан:	Овог нэр Гарын үсэг	Огноо:		Цаг: мин		

Багажийн мэдээлэл	Үйлдвэрлэгч, загвар	Сериал дугаар	Шалгалт тохируулгын огноо	Хэмжилтээс өмнө тэг шалгалт хийсэн	
				☐ тийм	☐ үгүй

БОХИРДУУЛАГЧ, ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРИЙГ САЛГАЖ, ТУСГААРЛАСАН МЭДЭГДЭЛ

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭ

	Тийм	Үгүй	Тэмдэглэл
Амьсгал хамгаалах хэрэгсэл			
Хамгаалах хувцас			
Хамгаалалтын дуулга			
Хамгаалах гутал			
Нүдний хамгаалалтын шил			
Хамгаалалтын бээлий			
Бусад ХХХ			
Гал унтраагуур			
Аврах хэрэгсэл			
Түгжих, пайзлах			
Агааржуулалт			
Анхааруулах тэмдэг / хаалт			
Бусад хамгаалах арга хэмжээ:			
Агаарын чанарын явцын хэмжилт			
Харилцаа холбооны хэрэгсэл			

НЭВТРЭГЧ, ХЯНАЛТЫН АЖИЛТНУУДАД ӨГСӨН ТУСГАЙ ЗААВАРЧИЛГАА

Нэвтэрсэн ажилтныг ажиглаж, харилцах хэлбэр	☐ Харагдах байдлаар	☐ Шууд аман харилцаа	☐ Радио холбоо	☐ Телефон

ОСЛЫН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Онцгой үед холбогдох утасны дугаар:

ЗӨВШӨӨРӨГДСӨН АЖИЛТНЫ НЭР

	Нэвтэрсэн цаг: мин	Гарсан цаг: мин	ХО-н гарсан ажилтны гарын үсэг
Нэвтрэгч ажилтны нэр			
Хянагч ажилтны нэр			

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН: Овог нэр Гарын үсэг	ЗӨВШӨӨРЛИЙГ ЦУЦАЛСАН: Овог нэр Гарын үсэг
ЗӨВШӨӨРЛИЙГ ХЯНАСАН: Овог нэр Гарын үсэг	

Хавсралт 2.

ХЯЗГААРЛАГДМАЛ ОРЧНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАЯГТ

Байгууллагын нэр:		Огноо:	__он__сар__өдөр
ХО-ны байршил:			
ХО-ны тодорхойлолт:		Эрсдэлийн үнэлгээний төрөл	Анхны Давтан
Эрсдэлийн үнэлгээний зорилго:			

I. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Агаарын чанарын үнэлгээ	**Тийм**	**Үгүй**	**Хэмжилтийн дүн**
Хүчилтөрөгчийн түвшин 19.5-23.5%-иас бага эсвэл их			
Шатамхай хий, уур эрсдэлтэй түвшинд (LEL-аас их)			
Угаарын хий ЗДХ-ээс хэтэрсэн			
Хүхэрт устөрөгч хэтэрсэн			
Бусад хорт хий ЗДХ-ээс хэтэрсэн			
Тоос, агаар бохирдуулагч ЗДХ-ээс хэтэрсэн			

Агаарын чанарын хэмжилт хийсэн	Огноо:		Цаг: мин	
Багажийн мэдээлэл	Үйлдвэрлэгч, загвар	Сериал дугаар	Шалгалт тохируулгын огноо	Хэмжилтээс өмнө тэг шалгалт хийсэн
				☐ тийм ☐ үгүй

Физик, хими, механик, биологийн аюултай хүчин зүйлс	Тийм	Үгүй	**Эрсдэлийн үнэлгээ**		
			Өртөх магадлал (1-5 оноо)	Үр дагаврын зэрэг (1-5 оноо)	Эрсдэлийн түвшин (1-5 оноо)*
Дулаан, хүйтний стресс					
Шуугиан, доргионы өртөлт					
Ионжуулагч, ионжуулагч бус цацраг					
Шингэн, хуурай материалд живэх, дарагдах, сорогдох					
Хальтрах, бүдрэх, унах					
Орц, гарц саадтай, гарахад хөдөлгөөн хязгаарласан					
Цахилгааны хүчдэл					
Хамгаалалтгүй их эргэлт, хөдөлгөөнт механизм					
Даралтад хоолой, сав					
Халуун уур, ус зэрэг түлэгдэл үүсгэх аюул					
Гидравлик, пневматик төхөөрөмж					
Хуримтлагдсан энерги					
Арьс, нүд, амьсгалын зам цочроогч бодис					
Бохир ус, хаягдал, биологийн аюул					
Орчны онцлогоос хамаарасан бусад аюул:					
Орчны онцлогоос хамаарасан бусад аюул:					

***Тайлбар:** *Өндөр(4,) ноцтой (5) эрсдэлд хяналтын арга хэмжээ хэрэгжүүлнэ*

II.ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

А.Энергийн тусгаарлалт (түгжих, пайзлах хяналт)		**Б.Агаар дахь аюултай хүчин зүйлсийн хяналт**	
Цахилгааны	☐	Механик агааржуулалт	☐
Механикийн	☐	Агаарын чанарын тогтмол хийх мониторинг	☐
Гидравлик, пневматик	☐	Агааржуулж цэвэрлэгээ хийх	☐
Шугам хоолойг хоослох, даралтгүй болгох	☐	Зөвшөөрөлгүй өндөр хэмийн ажлыг хориглох	☐
Давхар хаалт, гоожуулалт	☐		
Химийн бодисын хаягдалыг зайлуулах	☐		
В.Хувийн хамгаалах хэрэгсэл			
Агаар нөөцлөгчтэй амьсгалын аппарат	☐	Химийн бодист тэсвэртэй, ус нэвтрүүлдэггүй хувцас	☐
Агаарын хангамжтай амьсгал хамгаалах хэрэгсэл	☐	Хамгаалах дуулга	☐
Агаар цэвэршүүлэгчтэй амьсгал хамгаалах хэрэгсэл	☐	Хамгаалах нүдний шилд	☐
Хамгаалах бээлий	☐	Газ детектор	☐
Хамгаалах гутал	☐	Сонсгол хамгаалах хэрэгсэл	☐

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:	ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ОВОГ НЭР ГАРЫН ҮСЭГ	ОВОГ НЭР ГАРЫН ҮСЭГ

6 ХЭСЭГ: БУСАД НОЦТОЙ АЮУЛУУД														**Тийм**	**Үгүй**
18	Бусад ноцтой хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн аюул байгаа юу? *Хэрэв **тийм** бол дараах аюулуудыг сонгоно уу.*														
19	Цахилгаан:		Хөдөлгөөнт эд анги:						Халтирах/Унах:						
20	Хэт халалт/Хүйтэн:		Шуугиан/Доргион:						Химийн бодис:						
21	Арьс/Нүд цочроогч бодис:		Даралттай уур/ Конденсат:						Хамгаалалтгүй машин механизм:						
22	Пвевматик энерги:		Гидравлик энерги:						Хуримтлагдсан энерги:						
23	Бусад *(тодорхойлох)*:														
7 ХЭСЭГ: НЭВТРЭХ ГАРЦ															
24	Суурилсан шат:		Зөөврийн шат:		Шат:		Хаалга:		Таг:		Ил худаг:		Доош буулгах төхөөрөмж::		
25	Бусад *(тодорхойлох)*:														
8 ХЭСЭГ: АГААРЖУУЛАЛТ															
26	Байхгүй:		Байгалийн агааржуулалт (таагүй):		Байгалийн агааржуулалт (таатай):		Механик:								
27	Энэхүү орчинд механик агааржуулалт шаардлагатай эсэх:														
9 ХЭСЭГ: АВРАХ АЖИЛЛАГАА														**Тийм**	**Үгүй**
28	Энэхүү орчинд ажилтныг аврах үйл ажиллагаа явуулах хэрэгсэлд **тохиромжтой** дотоод зохион байгуулалттай юу?														
29	Энэхүү орчинд ажил хийгдэж байгаа газраас шалтгаалан, ажилтныг аврах үйл ажиллагаа явуулах хэрэгсэлд **тохиромжгүй** дотоод зохион байгуулалттай юу?														
30	Хэрэв аврах хэрэгсэл **тохиромжгүй** бол гаднаас аврах үйлчилгээ үзүүлэх шаардлагатай юу?														
10 ХЭСЭГ: ТОДОРХОЙЛОЛТ														**Тийм**	**Үгүй**
31	Энэхүү орчин нь зөвшөөрөл шаардлагатай хязгаарлагдмал орчин мөн үү? *Хэрэв 8, 12, 15 эсвэл 18 "**тийм**" бол зөвшөөрөл шаардана.*														
11 ХЭСЭГ: ТЭМДЭГЛЭЛ															
32															
12 ХЭСЭГ: АЮУЛТАЙ ЭНЕРГИЙГ ТУСГААРЛАХ															
	Хязгаарлагдмал орчинд **нэвтрэхээс өмнө** 3-6 хэсгүүдэд заасан аюулуудыг тусгаарлах эсвэл саармагжуулах үйл ажиллагаа хийж болзошгүй.														